

“СИТИ” Их сургуулийн бакалаврын өдрийн
хөтөлбөрт 2021-2022 оны хичээлийн
жилд оюутан элсүүлэх журам”
батлах тухай

Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, “Босго оноо тогтоох тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/187 дугаар тушаал, “СИТИ” Их сургуулийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“СИТИ” Их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2021-2022 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. “СИТИ” Их сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн элсэлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Сургалтын бодлого, зохицуулалтын газар /Х.Наранхүү/, Маркетингийн газар /Г.Баясгалан/ болон бүрэлдэхүүн сургуулийн захирлууд /Г.Алтантовч, Б.Одонгэрэл, И.Ундрахгэрэл, Д.Отгонзаяа, Ч.Дэлгэрцэцэг, Н.Чанцалдулам/-д тус тус үүрэг болгосугай.

3.Элсэлтийн үйл ажиллагааны явц, үр дүнг нэгтгэн тухай бүр танилцуулж ажиллахыг Сургалтын бодлого, зохицуулалтын газар /Х.Наранхүү/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” “СИТИ” Их сургуулийн Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.БАЙГАЛМАА

“СИТИ” Их сургуулийн Ерөнхийлөгчийн 2021 оны
___ дугаар тушаалын хавсралт

“СИТИ” ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ
2021-2022 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ОЮУТАН
ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“СИТИ” Их сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2021-2022 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх үйл ажиллагаанд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/79 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, “Босго оноо тогтоох тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/187 дугаар тушаал болон энэ журмыг баримтална.

1.2.Энэ журмын зорилго нь шалгуулагчдын ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадвар, авьяасыг бодитойгоор үнэлж, цаашид амжилттай суралцах чадвартай хүмүүсийг сонгон элсүүлэхэд оршино.

Хоёр. Ерөнхий шалгалт

2.1.“СИТИ” Их сургуульд элсэх бүрэн дунд боловсролтой иргэн элсэгчийн ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий Ерөнхий шалгалт өгнө.

2.2.Ерөнхий шалгалтыг Боловсролын үнэлгээний төв үндэсний түвшинд зохион байгуулна.

2.3.Ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичиг түүнийг олгосон өдрөөс хойш 2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй байна.

Гурав. Тусгай шалгалт

3.1.“СИТИ” Их сургуулийн сэтгүүл зүй болон сургуулийн өмнөх боловсролын багш, дуу хөгжмийн багш, гадаад хэлний багшийн бакалаврын хөтөлбөрт элсэгч нь дараах тусгай шалгалт өгсөн байна. Үүнд:

3.1.1.уран зохиол (тухайлбал, шүлэг, өгүүлэл уншиж, танилцуулах, телевизийн киноны зохиол, хүүхэлдэйн киноны эх зохиолын төлөвлөгөө, санаа гаргах, бичсэн өгүүллэг, нийтлэл, зохиол зэргийн аль нэг нь);

3.1.2.монголын түүхийн мэдлэг;

3.1.3.ярилцлага (өөрийгөө яруу тод илэрхийлэх, асуудалд шүүмжлэлтэй хандах г.м).

3.2.Архитектур, барилгын инженер, график дизайн, интерьер дизайн болон урлагийн сургуулийн бакалаврын хөтөлбөрт элсэгч нь дараах тусгай шалгалтыг өгсөн байна. Үүнд:

3.2.1.архитектур, барилгын инженер, график дизайн, интерьер дизайн бакалаврын хөтөлбөрт элсэгч хар зургийн шалгалт өгнө;

3.2.2.жүжиглэх, дуулах, бүжиглэх, хөгжмийн урлагийн бакалаврын хөтөлбөрт элсэгчийн авьяас, ур чадвар буюу сонголт, ритм, этюд, дуу, шүлэг, анхаарал, хөдөлгөөний, бүжгийн эвслийг шалгана.

3.3.Тусгай шалгалтын товыг 2021 оны 8 дугаар сард багтаан “СИТИ” Их сургуулиас тогтоож, нийтэд зарлана.

Дөрөв. Оюутан элсүүлэх хөтөлбөр
/мэргэжил/-ийн чиглэл

№	Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөрийн нэр	Элсэлтийн ерөнхий шалгалт	
			Суурь хичээл /410 оноо/	Дагалдах хичээл /400 оноо/
1	Бизнесийн сургууль	-Нягтлан бодох бүртгэл -Менежмент -Маркетинг -Худалдаа -Зочлох үйлчилгээ /зочид буудал, зоогийн газар/ -Аялал жуулчлал -Агаарын тээврийн үйлчилгээ	- Математик - Нийгмийн тухай мэдлэг - Гадаад хэл	- Монгол хэл - Монголын түүх - Газар зүй - Гадаад хэл - Нийгмийн тухай мэдлэг - Математик
2	Хууль зүйн сургууль	- Эрх зүй	-Нийгмийн тухай мэдлэг	- Гадаад хэл - Математик - Монгол хэл
3	Хүмүүнлэгийн сургууль	- Багш, гадаад хэлний боловсрол /англи, орос/ - Багш, сургуулийн өмнөх насны боловсрол - Багш, урлагийн боловсрол - Гадаад хэлний орчуулга /англи, хятад, япон, солонгос, франц/ - Сэтгүүл зүй	- Гадаад хэл - Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг - Монголын түүх - Математик	- Монгол хэл - Монголын түүх - Математик - Нийгмийн тухай мэдлэг - Гадаад хэл
4	Гоо сайхны сургууль	- Химийн технологи /Гоо сайхны бүтээгдэхүүний технологи/ - Гоо заслын урлаг, технологи - Сувилахуй	- Хими - Нийгмийн тухай мэдлэг - Монгол хэл - Англи хэл	- Биологи - Монгол хэл -Нийгмийн тухай мэдлэг - Англи хэл - Орос хэл - Монголын түүх
5	Барилга, архитектур, дизайны сургууль	- Програм хангамж - Хувцасны дизайн - График дизайн - Интерьер дизайн - Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи /ноос, ноолуур/ - Архитектур - Барилгын инженер	- Нийгмийн тухай мэдлэг - Математик - Физик - Хими	- Математик - Физик - Хими - Нийгмийн тухай мэдлэг - Монголын түүх - Гадаад хэл - Монгол хэл - Ур чадвар

6	Урлаг	<ul style="list-style-type: none"> - Дуулах урлаг - Жүжиглэх урлаг - Хөгжмийн урлаг - Бүжгийн урлаг 	<ul style="list-style-type: none"> - Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг 	<ul style="list-style-type: none"> - Гадаад хэл - Монголын түүх - Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг - Ур чадвар
---	-------	---	---	---

Тав. Элсэлтийн ерөнхий шалгалт өгөөгүй байх тохиолдол

5.1. Дараах тохиолдолд элсэлтийн ерөнхий шалгалт өгөөгүй байж болно. Үүнд:

5.1.1. дээд боловсролтой иргэн хоёр дахь дээд боловсрол эзэмших;

5.1.2. дипломын боловсролтой, тусгай мэргэжлийн дунд сургуулийг төгсөөд мэргэжлийнхээ дагуу бакалаврын хөтөлбөрт элсэх;

5.1.3. гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, батламж авсан.

5.2. Элсэхийг хүссэн гадаадын иргэнийг Монгол Улсын бүрэн дунд боловсролтой дүйцэх бичиг баримтыг үндэслэн элсүүлнэ.

5.3. Бакалаврын зэргийн боловсролтой иргэн дараагийн дээд боловсрол эзэмших хүсэлтэй бол өмнө нь төгссөн сургуулийн дээд боловсролын дипломыг үндэслэн элсүүлнэ.

Зургаа. Элсэлтийн үйл ажиллагааны зохион байгуулалт

6.1. "СИТИ" Их сургуулийн Сургалтын бодлого, зохицуулалтын газар болон Маркетингийн газар элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулна.

6.2. Аймаг, орон нутгаас оюутан элсүүлэх ажлыг Монголын их, дээд сургуулиудын консерциум /МИДСК/-ын шугамаар зохион байгуулна. Мөн сургуулийн ерөнхийлөгчийн тушаалаар зарим аймагт элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж болно.

6.3. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа нь ил тод, шударга, тэгш байдлыг хангасан байна.

6.4. Элсэлтийн зар сурталчилгаа, үйл ажиллагаа үнэн зөв, ойлгомжтой байж, шалгуулагч бүрэн мэдээлэлтэйгээр сургууль, мэргэжлээ сонгох боломжийг хангасан байна.

6.5. Ерөнхий чиглэлээр эхэлж элсүүлээд, сургалтын явцад нарийвчилсан мэргэжлийн чиглэлээ тогтоох мэргэжилд сургалтын хэд дэх жилээс ямар мэргэжлийн чиглэл сонгох боломжтой талаар шалгуулагчдыг мэдээллээр хангана.

6.6. Элсэлтийн бүртгэлийн хураамж нь бүртгэл хийх, бичиг баримт хүлээн авах, үнэлэх, шалгах зэрэг үйл ажиллагааны зардалд зарцуулагддаг тул элссэн

эсэхээс үл хамааран буцаан олгогдохгүй. Харин бүртгэлийн хураамж төлсөн бол сургуулийн санал болгож байгаа бусад мэргэжлийн хөтөлбөрөөс сонгох давуу тал олгогдоно.

Долоо. Элсэлтийн бүртгэл

7.1.Улаанбаатар хотод элсэгчдийг 2021 оны 06 дугаар сарын 05-наас эхлэн өөрийн байранд бүртгэнэ.

7.2.Бүрдүүлэх материал:

- Ерөнхий шалгалтын батламж;
- Боловсролын үнэмлэх, гэрчилгээ, дипломын хуулбар;
- Сурагчийн хувийн хэрэг;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- 3x4 хэмжээний цээж зураг 2 хувь;
- Бүртгэлийн хураамж 10,000,00 /арван мянга/ төгрөг.

7.3.Элсэгч нь “СИТИ” Их сургуулийн албан ёсны цахим хуудсаар дамжин элсэх хүсэлт гаргах боломжтой. Үүний тулд:

а/www.citi.edu.mn/online_registration хаягаар орж суралцах хөтөлбөрийн төрлөө сонгоно;

б/гарч ирэх цонхонд харагдах нүднүүдэд шаардлагатай мэдээллүүдийг үнэн зөв, крил үсгээр оруулан “Бүртгүүлэх” товчийг дарж хүсэлтээ бүртгүүлнэ;

в/“бүртгүүлэх” товч дарснаар төлбөр төлөх хэсэх гарч ирэх ба төлбөрөө ухаалаг утас болон банкны аппликейшны QRay болон SocialPay цэсээр төлж бүртгэлээ баталгаажуулна;

г/мөн элсэх хүсэлтээ Ерөнхий шалгалтын батламж, иргэний үнэмлэх болон бүртгэлийн хураамж төлсөн баримтын цахим хуулбарын хамт admin@citi.edu.mn хаягаар ирүүлнэ.

7.4.Элсэгч 2021 оны 8 дугаар сарын 25-29-ний хооронд сургууль дээр ирж бүртгүүлэх бөгөөд онлайнаар бүртгүүлсэн элсэгч энэ журмын 7.2-т заасан бичиг баримтыг эх хувиар нь авчирч Сургалтын бодлого, зохицуулалтын газарт хүлээлгэн өгнө.

7.5.МИДСК-ын хөтөлбөр сонголтоор суралцах эрхийн бичиг авсан элсэгч тогтоосон хугацаанд сургууль дээр ирж бүртгүүлснээр суралцах эрх нь нээгдэнэ.

7.6.Хэрэв хуурамч бичиг баримт бүрдүүлсэн ба бүрдэл дутуу бол тухайн элсэгчийг элсэлтийн бүртгэлээс хасах эрхтэй.

Найм. Элсэлттэй холбоотой маргаан шийдвэрлэх

8.1.Сургалтын бодлого, зохицуулалтын газар нь тухайн элсэгчийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

8.2.Ерөнхий шалгалттай холбоотой маргааныг Сургалтын бодлого, зохицуулалтын газар хариуцахгүй.

-----oOo-----